



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар АБ26

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4, 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XI хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын гаргасан саналыг харгалзан газар эзэмших хүсэлт гаргасан аймгийн Цагдаагийн газарт (9070192) 14 дүгээр баг Герман мэдээллийн төвийн ард байрлалтай 1 га газрыг төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа төрийн байгууллагатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, газрын кадастрын мэдээллийн санд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН